

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

## САЙД НАРТ

Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн хуралдааны 68 дугаар тэмдэглэлд:

“ХИИ.2. Хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийн 2012 оны III улирлын дүнг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ч.Сайханбилэг Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан:

2.1. Эрхлэх асуудлынхаа хүрээнд хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийн байдалд хяналт-шинжилгээ хийж хэрэгжүүлэх шаардлагагүй болон боломжгүй болсон шийдвэрүүдийн талаар санал боловсруулж Засгийн газарт оруулахыг сайд нарт даалгав.

2.2. Улсын Их Хурлын тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг шуурхай зохион байгуулах, 2012 оны III улирлын байдлаар тасарсан болон хэрэгжилт нь удааширч байгаа заалтуудыг хэрэгжүүлж ажиллахыг сайд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав.

2.3. Засгийн газрын 2006 оны 160 дугаар тогтоолоор баталсан “Хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, үр дүн, биелэлтийг дүгнэх, мэдээлэх журам”-д хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг үнэлэхэд чанарын үзүүлэлт харгалзах, Засгийн газрын агентлагуудын тайланг үнэлгээнд хамруулах чиглэлээр нэмэлт, өөрчлөлт оруулж шинэчлэн батлуулахыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ч.Сайханбилэгт даалгав.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР